



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 11/02

Хөхбүрд

Өмч хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Өмч хөрөнгийн тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|------------|----------------|-------------------------------|
| Ахлагчаар: | Д.Гансүх | (Хурлын төлөөлөгч) |
| Гишүүн: | Д.Батбаатар | (Хурлын нарийн бичгийн дарга) |
| | Ц.Жамбалдорж | (Хурлын төлөөлөгч) |
| | Б.Эрдэнэбаатар | (Хурлын төлөөлөгч) |
| | Д.Жамбажамц | (Хурлын төлөөлөгч) |

2. Сумын хэмжээний өмч хөрөнгийн тооллогыг байгууллага тус бүрийн бүртгэлтэй тулган, биечлэн тоолж, хариуцлагатай зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Тооллогын тайлан, мэдээг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулж, дараагийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхийг ажлын хэсэг, ахлагч (Д.Гансүх)-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Отгонбаяр)-т хариуцуулсугай.

ДАРГА  Б.ОТГОНБАЯР



648801061